



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЦААНЫ СУРГУУЛЬ

75-80

196-

VOL. 196 (6)
2002 №2

ББК
72
О-29

ОЛОН УЛСЫН ХАРИЦАА WORLD AFFAIRS



Тус сэтгүүл нь анх 1996 оноос "Алтан аргамж" нэрээр, 2002 оноос "Олон улсын харилцаа" нэрээр гарч байна.

Сэтгүүлийн зөвлөл:

Эрхлэгч:

Н.Алтанцэцэг (проф.доктор Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Д.Тунгалаг (дэд.проф.доктор Ph.D)

Гишүүд:

Ж.Баясах (тэр.проф.доктор Ph.D)
Ц.Гүрбадам (проф.доктор Sc.D)
Д.Цолмон (тэр.проф.доктор Ph.D)
Ж.Бор (проф.доктор Ph.D)
С.Отгонбаатар (дэд проф.доктор Ph.D)
Л.Даваадэлгэр Ахлах багш

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

С.Энхцэцэг

Сэтгүүлийн хаяг:

МУИС-ийн Олон улсын
харилцааны сургууль
Шуудангийн хайрцаг – 46 а
Улаанбаатар, Монгол улс
Утас: 310091; 318640; 318121
Факс: (976-11) 311809
E – mail: sfs@num.edu.mn

The journal has been published since 1996 as "Altan argamj" and since 2002 as "World Affairs".

Editorial Board:

Editor in Chief:

N.Altantsetseg (Prof.Ph.D)

Assistant Editor:

D.Tungalag (Prof.Ph.D)

Members:

J.Bayasakh (Prof.Ph.D)
Ts.Gurbadam (Prof.Sc.D)
D.Tsolmon (Prof.Ph.D)
J. Borr (Prof.Ph.D)
S.Otgonbaatar (Prof.Ph.D)
L.Davaadelger Senior Lecturer

Typist:

S.Enkhtsetseg

Editorial Address:

School of Foreign Service
Mongolian National University
P.O.Box – 46 a
Ulaanbaatar, Mongolia
Tel: 310091; 318640; 318121
Fax: (976-11) 311809
E – mail: sfs@num.edu.mn

АГУУЛГА

Тэргүүн өгүүлэл

Дипломат албаны 90 жилийн ойн баярын хуралд Гадаад Хэргийн сайд Л.Эрдэнэчулууны хэлсэн үг	5
--	---

I. МУИС-ийн ОУХС-ийн 10 жилийн ойн эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл

1. Н.Алтанцэцэг	МУИС -ийн ОУХС байгуулагдсаны 10 жилд.....	11
2. Бат.Ганболд	Дипломат албаны боловсон хүчин бэлтгэх асуудалд	16
3. Д.Цолмон	Даяаршил ба буурай хөгжилтэй орнуудын эрх ашиг, аюулгүй байдлын зарим асуудал.....	21
4. Х.Олзвой	Монголчууд Евразийн геополитиктой холбогдох нь	29
5. Ж.Баясах	Монгол улсын гурав дахь хөрш хийгээд түншийн асуудалд	36
6. Paul Meerts	Даяаршлын эрин үе дэх жижиг улсуудын гэрээ хэлцэл	42
7. Ц.Баатар	Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа: XX зууны сүүлийн 10 жилд.....	48
8. Д.Уламбаяр	Монгол улсын дипломат албаны үндэс суурь тавигдсан нь	60
9. Ж.Бор	Монголын улс төрийн сэтгэлгээн дэх олон улсын харилцааны үзэл санаа	72
10. С.Отгонбаатар	Зүүн Хойд Азийн бүс нутгийн интеграцийн асуудалд	75
11. Д.Баярхүү	Өмнөд Ази дахь геополитикийн шинэ хувьсал.....	80
12. Д.Өлзийдолгор, Д.Наранцэцэг	Монгол улсын гадаад харилцаа, тусгаар тогтнолын асуудалд (1946 - 1961)	85

II. Монголч эрдэмтдийн VIII их хурал болон бусад олон улсын бага хуралд тавьсан илтгэл

1. Н.Алтанцэцэг	90-ээд оноос хойшхи үеийн Орос - Монгол, Хятад - Монголын харилцаа.....	90
2. Л.Даваадэлгэр	Даяаршлын үеийн Монголын эдийн засгийн дипломат бодлого.....	98
3. Stephen E.Noerper	ЗХА-ийн аюулгүй байдлын шинэ орчин нөхцөл.....	106



CONTENTS

Leading article

- Speech of L.Erdenechuluun, Minister for Foreign affairs on the occasion of the 90th anniversary of the Mongolian diplomatic service5

I. Reports delivered at research conference devoted to the 10th anniversary of the School of Foreign Service establishment, the National University of Mongolia

1. Altantsetseg N 10 years of the School of Foreign Service, the NUM11
2. Ganbold Bat To the issues of diplomatic service personnel training.16
3. Tsolmon D Problems of Security and National interests of small states and globalization21
4. Olzvoy Kh Connections of the Mongolians to the Euroasian Geopolitics29
5. Bayasakh J To the issues of Mongolia's third neighbor36
6. Paul Meerts Negotiation Opportunities for Small States in a Globalizing World.....42
7. Baatar Ts Mongolian foreign economic relations at the end of the 20th century..... 48
8. Ulambayar D Foundation of diplomatic service of Mongolia..... 60
9. Borr J Concepts of international relations in the Mongolian political thinking 72
10. Otgonbaatar S Issues of the North East Asian integration..... 75
11. Bayarkhuu D Evolution of the South Asian Geopolitics..... 80
12. Ulziidolgor D Narantsetseg D Issues of sovereignty and foreign relation of Mongolia (1946-1961)..... 85

II. Reports made at VIII International Congress of Mongolists and other international conferences

1. Altantsetseg N Russian – Mongolian, Chinese – Mongolian relations in the 90ies..... 90
2. Davaadelger L Mongolian economic diplomacy in the age of Globalization..... 98
3. Stephen E.Noerper Horseman and Hermits: Mongolia, North Korea and the new security architecture in North East Asia106

ТЭРГҮҮН ӨГҮҮЛЭЛ

ДИПЛОМАТ АЛБАНЫ 90 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ХУРАЛД ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУНЫ ХЭЛСЭН ҮГ

*Монгол улсын хүндэт Ерөнхийлөгч өө,
Хүндэт Ерөнхий сайд аа,
Эрхэм хүндэт зочид өө,
Хүндэт дипломатчид аа,*


Монголчууд XX зууны эхнээс төр улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг сэргээж, төрийн гадаад харилцаагаа төвхнүүлэн хөгжүүлэх үйлсэд нэгэн зууны туршид хүчин зүтгэн амжилтанд хүрснээр XXI зуунтай золгож, өнөөдөр эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлж байна.

Эх орныхоо тусгаар тогтнолыг сэргээх, түүнийг бататган бэхжүүлэх үйлсэд Монгол улсын дипломат алба чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн юм. Монгол улсад дипломат алба байгуулагдсанаас хойш эдүгээ хүртэл 90 жилийг ардаа орхижээ. Өнгөрсөн хугацаан дахь манай улсын гадаад харилцаа Монгол улсын улс төр, нийгмийн хөгжилтэй салшгүй холбоотой бөгөөд дипломат албаны 90 жилийн түүх нь Монгол улсын эрх чөлөө, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг ханган баталгаажуулахын төлөөх амаргүй тэмцлийн он жилүүд байсан юм. Энэхүү тэмцлийн тэргүүн эгнээний байлдагчид болох Монгол улсын үе үеийн дипломатчидад, юуны өмнө ахмад үеийхэнд энэ хүндэт ойн өндөрлөгөөс чин сэтгэлийн халуун баяр хүргэж, та бүхний зүтгэл тэмцлийг монголын ард түмэн, төр засаг өндрөөр үнэлж, ямагт дурсан санаж байдгийг илэрхийлж байна.

XX зуун бол манай улсын хувьд үндэсний сэргэн мандлын эрин үе байлаа. Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх эх орончийн хоёр зуу гаран жил үргэлжилсэн тэмцлийн үр дүнд 1911 онд Олноо өргөгдсөн Монгол Улс тогтсон нь Монголын тулгар төр, гадаад ба дипломат харилцааны нэгэн чухал үе болсон юм.

XVI жарны цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9 буюу 1911 оны 12-р сарын 29-ний өдрөөр орчин үеийн Монгол Улсын дипломат албаны шинэ цаг тооны хуанли эхэлдэг. Эл өдөр Богд гэгээний зарлигаар тусгаар тогтносон Монгол улсын Засгийн газрыг таван яамтайгаар байгуулсны нэг нь Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэх яам байсан бөгөөд тус яамны анхны сайдаар үндэсний эрх чөлөөний нэрт зүтгэлтэн Чин ван Ханддоржийг тохоон томилсон түүхтэй.

Монголчууд төрийн гадаад харилцаагаа журамлан явуулж байсан эртний түүхтэй улс юм. Монгол төрийн гадаад харилцаа зөвхөн 1911 оноос хойш 90-хэн жилээр хязгаарлагдахгүй гэдгийг бид мэднэ. Эртний Хүннү улсад хэдийгээр дэв зэргийн хувьд хялбар зохион байгуулалттай боловч төрийн хэмжээнд зохион байгуулагдсан "Дипломат алба", Монголын нэгдсэн улсын үед "Төрийн хэрэг эрхлэх газар", "Нууц бичгийн



яам" зэрэг байгууллагыг байгуулж гадаад дахинтай харилцах асуудлыг эрхлүүлж байсан бөгөөд эдгээр нь төрийн байгууллага, яамдын анхны хэлбэрүүд байжээ.

1911 онд байгуулагдсан Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэх яам нь Монголын тулгар төр дахин сэргэн мандсан үеийн гадаад хэргийн асуудал эрхэлсэн орчин цагийн хэлбэртэй, төрийн захиргааны төв байгууллагын шинэ үеийн эхлэлийг тавьсан юм.

Чухамхүү XX зууны эхэн үеэс Монгол улс нь олон улсын тавцнаа бие даасан гадаад бодлого явуулж шинэ Монгол улс бий болсныг орчин үеийн соёлт ертөнцийн сонорт хүргэсэн юм. Олноо өргөгдсөн Монгол улс байгуулагдмагц гадаад улсаас хараат бус байдлаар өөрийн дотоод, гадаад бодлогыг явуулахыг эрмэлзэж, өөрийн улсын тусгаар тогтнолыг умард, өмнөд хөршөөрөө хүлээн зөвшөөрүүлэх, улмаар хэвийн харилцаа тогтоох, тухайн үед дэлхийн бодлогыг тодорхойлж байсан томоохон улс гүрэнтэй харилцаа, холбоо тогтоохыг чухал зорилт болгон тэмцсэн билээ. Энэ нь угтаа улс орныхоо тусгаар тогтнолыг олон улсын эрх зүйн үүднээс баталгаатай болгох гэсэн шинэ цагийн Монгол улсын дипломат үйл ажиллагааны эхний үе шат байсан ажээ.

Тэртээ 90 жилийн өмнө манай өвөг дээдсийн маань санан хүсэж байсан төрийн тусгаар тогтнол, зориглон эхлүүлсэн бие даасан гадаад бодлогыг үе үеийн туршид залгамжлан явуулахад бидэнд ололт амжилтын зэрэгцээ хүндрэл бэрхшээл багагүй байсан билээ. Монгол улс нутаг дэвсгэрээ харийн түрэмгийлэгчдээс бүрэн чөлөөлөх, туурга тусгаар улсаа сэргээхэд 1921 онд өрнөсөн Ардын хувьсгал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа бусад гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэхэд 1945 оны Ялтын хэлэлцээр нь чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Олон жилийн туршид уйгагүй хүчин чармайлт гаргаж ирсний үр дүнд Монгол улс 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн болсон нь Монгол улсыг олон улсын тавцанд бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрсний илрэл болсон юм. Энэ бол Монгол улсын төр засаг, манай дипломатчидын уйгагүй тэмцлийн бодит үр дүн байлаа.

Энэ онд Монгол улс НҮБ-д элссэний 40 жилийн ой болж НҮБ, түүний системийн байгууллагуудтай хөгжүүлж ирсэн хамтын ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, ойрын жилүүдийн чиглэл, хүрээг хамтран тодорхойлох, Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд эдгээр байгууллагаас оруулсан хувь нэмэр, хамтын ажиллагааны үр дүнг олон нийтэд өргөн таниулах чиглэлээр уг ойг тэмдэглэв.

Өнөөдөр Монгол улс НҮБ-ын ихээхэн идэвх санаачилгатай ажилладаг нэг гишүүн нь болж чадсаныг энэ түүхт ойн өдөр тэмдэглэхэд нэн таатай байна.

Олон улсын харилцаанд ноёрхож байсан "Хүйтэн дайн" дуусч, хоёр туйлт ертөнц 1980-аад оны сүүлчээр задран унаснаар Монгол улс бие даасан гадаад бодлогоо хэрэгжүүлэх аятай, түүхэн цаг үетэй золгосон юм. Манай орон ардчилсан ёс, олон ургальч үзэл, зах зээлийн эдийн засгийн замыг сонгон авсан хийгээд улс төр, нийгэм, эдийн засгийн салбарт тууштай өөрчлөлт, шинэчлэл хийж эхэлсэн нь улс үндэстнийхээ ашиг

сонирхлыг дээдэлсэн, бодит байдалд тулгуурласан гадаад бодлого явуулах таатай боломжийг бүрдүүлж өгөв.

Түүхэн шинэ үе дэх Монгол улсын гадаад бодлого нь зорилго, зарчим, чиг хандлагын хувьд дорвитой шинэчлэгдэн өөрчлөгдсөн билээ. Манай гадаад бодлого өнөөдөр Монгол улс, монголын ард түмэн, үндэсний язгуур эрх ашгийг олон улсын тавцанд туунштай хамгаалахад бүрэн чиглэж байна.

Энх тайванч, олон түшигт, нээлттэй, нэгдмэл гадаад бодлого явуулж, хүн төрөлхтний хөгжлийн жам ёсыг даган бүх улс оронтой найрсаг харилцах, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, бүс нутгийн болон дэлхийн улс оронтой улс төр, эдийн засгийн нягт харилцаа тогтоож эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах нь Монгол улсын гадаад бодлого, манай дипломатчидын үйл ажиллагааны эрхэм зорилт болж байгаа билээ.

Монгол улсын дипломат албыг 90 жилийн ойн өндөрлөгөөс эргэн харахад Монгол улс 1948 он хүртэл ганцхан ЗХУ-тай Дипломат төлөөлөгчийн газраа харилцан солилцсон, 20 гаран жил үндсэндээ энэ улстай харилцаатай, тухайн улсаар зөвшөөрөгдсөн байдалтай явж ирсэн билээ. Тэгвэл өнөөдөр Монгол улс дэлхийн 141 улстай дипломат харилцаатай, Засгийн газрын 33, бүс нутгийн 20-иод олон улсын байгууллагын гишүүн, гадаадад 25 Дипломат төлөөлөгчийн болон Байнгын төлөөлөгчийн газартай, 6 тойргийн Ерөнхий консулын газартай, 29 оронд улсаа төлөөлсөн 39 өргөмжит консул ажиллуулж байна. Товчоор хэлбэл XX зууны сүүлийн 50 гаруй жил бол Монгол улсын гадаад харилцаа, Монголын дипломат албаны хөгжлийн оргил үе байсан гэж хэлэх бүрэн үндэстэй юм.

Эрхэм ноёд, хатагтай нар аа,

Бидний амьдарч буй үе бол даяаршлын үйл явц эрчимтэй өрнөж, дэлхий дахинаа олон улсын харилцаа, олон талт хамтын ажиллагааны үүрэг оролцоо, ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байгаа эрин юм. Энэ үед манай гадаад бодлого нь улс орны хөгжил цэцэглэлтийг хангахад нэн чухал үүрэг бүхий үр нөлөөтэй хэрэгсэл болон хувирч байгааг хэлмээр байна. Өнөөдөр гадаад харилцаанд оролцдоггүй тийм төр захиргааны болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, хувь хүн бараг үгүй болоод байна. Гадаад харилцаа, үйл ажиллагаа ийнхүү өргөн хүрээг хамрах болсноор дипломатчид болоод гадаад харилцааны салбарт ажиллагсдын үйл ажиллагааны зааг хязгаар, хүрээ өргөжин тэлж, бид бүхний өмнө улам бүр шинэ зорилт, өндөр хариуцлага тулгарч байна.

Улс түмний уялдаа холбоо, харилцан хамаарал улам бүр өргөжин тэлж байгаа даяаршлын энэ эрин үед улс орнууд дангаараа шийдэж чадахгүй буюу боломжгүй асуудлууд, тухайлбал, байгаль орчны асуудал, олон улсын терроризм, үндэстэн дамнасан гэмт хэрэг, ядуурал, цагаачлал, халдварт өвчний тархалт зэрэг асуудлын тоо хэмжээ өсөж, хамрах хүрээ нь өргөжин тэлж байгаа нь Монгол улс дэлхийн улс орнуудтай олон

улсын болон бүс нутгийн хэмжээнд харилцаа, хамтын ажиллагааг улам бүр идэвхжүүлэн бэхжүүлэхийг шаардаж байна.

Ардчилсан ёс, засаглал дэлхий дахинаа бэхжин, харилцаа холбоо улам бүр асар хурдтай болсон өнөө үед засгийн газрууд ард түмнийхээ хэрэгцээ, шаардлагыг хангах, түүнд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах нь хэдийнээ бодит зүйл болжээ. Ард түмнийхээ аюулгүй байдлыг бат найдвартай хангах, амар амгалан байлгах нь ямар ч улсын төр засгийн гадаад бодлогын гол зорилт байсаар ирсэн билээ.

Өнөөгийн Монгол улс өөрийн аюулгүй байдлыг аливаа цэрэг, улс төрийн эвсэл холбоонд нэгдэх замаар бус, харин бүх улс гүрэнтэй эвсэг сайн харилцаатай байх, харилцан ашигтай хамтын ажиллагааг тууштай хөгжүүлэх үндсэн дээр улс төр, дипломатын аргаар ханган хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна. Монгол улсыг цөмийн зэвсэггүй бүс болгон тунхаглаж, түүнийг НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн орнууд дэмжиж хамтарсан мэдэгдэл гаргасан нь аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны нэг чухал хэсэг болно.

Эдүгээ аюулгүй байдлын асуудал нь үзэл баримтлалын хувьд шинэ ойлголт, шинэ агуулгаар баяжин, хамрах хүрээний хувьд өөрчлөгдсөөр байгааг энд мөн тэмдэглэх нь зүйтэй болов уу. Улс хоорондын дайн дажин, зэвсэгт мөргөлдөөн, үй олноор хөнөөх зэвсгийн тархах аюул, ердийн зэвсгээр хөөцөлдөх явдал, газар нутаг, нутаг дэвсгэрийн маргаан зэрэг аюулгүй байдлын асуудлууд нь "Хүйтэн дайн"-ы үеийнх шиг орон зай, цаг хугацааг хамрахаа болив. Гэтэл аюулгүй байдлын уламжлалт дээрх асуудлуудаас гадна өнөө үед олон улсын терроризм, хүрээлэн буй орчны доройтол, экологийн тэнцвэргүй байдал, байгаль цаг уурын өөрчлөлт, үндэстэн хоорондын мөргөлдөөн зэрэг уламжлалт бус аюулгүй байдлын асуудлууд хөндөгдөн гарч ирэх явдал илүүтэй болжээ. Өргөн утгаар авч үзвэл аюулгүй байдлын тухай асуудал нь бидний анхаарлыг уламжлалт газар нутгийн аюулгүй байдал гэхээсээ илүүтэй хувь хүн дээр төвлөрүүлж байна. Тухайн хувь хүн айх аюулгүй, гачигдах зовлонгүй байх, эрүүл саруул, сэтгэл хангалуун амьдарч, амьдралын сайн сайхныг ямар түвшинд хүртэх чадвартай байгаагаар улс орны хөгжлийн түвшин улам бүр тодорхойлогдох болж байна.

Засгийн газруудын үйл ажиллагааг хүний аюулгүй байдлын асуудлыг хир зэрэг буурьтай, үр нөлөөтэй шийдвэрлэж байгаагаар нь дүгнэх цэгнэх нь их болов. Энд ХХI зуун хүн төвтэй зуун зайлшгүй болохын учир шалтгаан оршиж буй юм.

ХХI зуунд даяаршлын үйл явц түгээмэл шинж чанартай болж, технологийн дэвшил асар хурдацтай өрнөж байна. Өнөөдөр даяаршилд хамрагдах, эс хамрагдах асуудал байхгүй. Энэ үйл явц хүссэн ч, хүсээгүй ч бүх улс гүрэн, хүн ардыг хамран өөрийн нөлөөг шууд үзүүлэх нь тодорхой болов. Иймд асуудлын гол нь уг үйл явцад ухамсартайгаар хэрхэн зөв оролцох вэ гэдэг асуудал болж байна.

Даяаршлын үйл явц нь бараа бүтээгдэхүүн, технологи, хөрөнгө мөнгөний урсгал өргөжих, олон улсын байгууллагын нөлөө хэлбэрэлтгүй өсөн бэхжих, интернетээр дамжин хил дамнасан харилцаа холбоо,

мэдээллийн солилцооны хүрээ ихээхэн тэлж өргөжих, орчин үед мэдээллийг түгээх, хүмүүс хоорондын харилцааг бэхжүүлэн өргөтгөх гэх мэтээр олон сайн талуудыг бий болгодог гадна буурай хөгжилтэй, жижиг орнуудын хувьд хөгжилд саад болох муу үр дагавартайг мөн анхаарах учиртай. Даяаршил нь мөн өвчин эмгэг, экологийн үр дагаврыг хил давуулан тараан дэлгэрүүлэх, зах зээл, өмч хөрөнгө, технологид нэвтрэх тодорхой төрлийн гэмт хэргийг үйлдэх явдал улам бүр олон улсын чанартай болж хувь хүн, нийгэм, төрийн тогтолцооны аюулгүй байдлын үндэс суурийг ганхуулах сөрөг үр дагаврыг төрүүлж болзошгүй байгааг анхаарахгүй байж болохгүй. Ялангуяа мэдээлэл хил хязгааргүй болж, шинжлэх ухаан, технологи хөгжихийн хирээр улс үндэстний өвөрмөц соёл, ёс заншил, үндэсний онцлог бүдгэрч арилахад хүрч болзошгүй юм. Нөгөө талаар, олон улсын терроризм, хар тамхины зөөвөр, бохир мөнгө угаах, зэвсгийн наймаа өргөжих, интернетээр дамжин санхүүгийн хууль бус үйлдэл хийх зэрэг улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд хор уршигтай, зохион байгуулалттай гэмт хэрэг гарахад таатай нөхцөл, хөрс суурь болох аюултайг бодолцох ёстой.

Олон улсын терроризм XXI зуунд дэлхийн улс түмнүүдэд нүүрлэсэн гол аюул занал болж хувираад байна. Олон улсын терроризмын аюулын тухай, түүнтэй хэрхэн яаж тэмцэх вэ гэдэг нь өнөө үед олон улсын харилцаа, дэлхийн бодлогын анхаарлын төвд байх асуудал болов. Орчин үеийн терроризм хил хязгааргүй, дэлхийн хэмжээний бүтэцтэй хүч болж, улмаар террористууд өөрсдийн зорилго, санаж хүссэндээ хүрч чаддаг болсонд түүний нэг онцлог, гол аюул оршино. Шинжлэх ухаан, технологи хөгжихийн хирээр мэдээллийн терроризм, био-терроризм зэрэг терроризмын олон талт арга хэлбэрүүдийг бий болгож, улам ээдрээтэй болж байгааг бид бүхэн анхааралтай ажиглаж байх ёстой.

Өнгөрсөн зууны эхэн үеэс эхлэн дэлхийн улс орнууд болоод олон улсын хамтын нийгэмлэг терроризмтай тэмцэж, түүнийг таслан зогсоох талаар ажиллаж ирсэн боловч террорист гэмт халдлагын тоо нэмэгдэж, террорист гэмт халдлагад өртөгсдийн тоо улам бүр өсөж байгаа юм. Террорист халдлага нь аливаа улс орны улс төрийн тогтолцоо, хөгжлийн түвшин, чадавхийг үл харгалзан түгэн тархах болсон нь хүн төрөлхтөн улам бүр эмзэг, өртөмтгий болж буйг харуулахын сацуу аюулгүй байдлын тухай бидний төсөөлөл, түүнийг хэрхэн хангах арга замын асуудлыг ч эргэж харах шаардлага тулгарч байна.

Олон улсын терроризм болон бусад үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын хамтын нийгэмлэг болох Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон талт хамтын ажиллагааны үүрэг роль чухал хэвээр байх ёстой бөгөөд улс орнуудын идэвхтэй санал санаачилга, нэгдмэл ойлголт, байр суурь чухал ач холбогдолтой гэдгийг энд тэмдэглэхийг хүсч байна. Энэ утгаар терроризмын эсрэг олон улсын нэгдсэн эвсэл байгуулагдах үйл явцыг Монгол улс сайшаан дэмжиж байгаа болно.

Хүндэт зочид оо,
Ажил мэргэжил нэгт анд нар аа,

Шинэ зуун дахь Монгол улсын дүр төрх ямар байх, даяаршлын үйл явцад манай улс хөлөө хэрхэн зөв олох, бүс нутаг, дэлхийн хэмжээний уламжлалт болон уламжлалт бус аюул, сөрөг нөлөөллийн хор уршгийг багасгах, Монгол улсын олон улсын тавцан дахь нэр хүнд, нөлөөг цаашид өсгөх, түүний аюулгүй байдлын гадаад орчинг шинэ нөхцөл байдалд нийцүүлэн улам бэхжүүлэх, бүс нутаг, тив, улмаар эдийн засгийн олон талт хамтын ажиллагаа, интеграцид зөв холбогдох, улс орны дотоодын нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд гадаад нэн таатай нөхцлийг бүрдүүлэх зэрэг нь Монгол улсын гадаад бодлого, манай дипломат албаны үйл ажиллагаанаас ихээхэн хэмжээгээр хамаарах юм. Шинэ нөхцөл байдал дахь томоохон сорилтуудыг даван туулж, гадаад бодлогын зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд өнөөгийн болон ойрын ирээдүйн монголын дипломатчидын нөр их хөдөлмөр, мэдлэг чадвар, авъяас билиг, дипломат албаны тууштай үйл ажиллагаа шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх ёстой гэж үзнэ. Манай эрин цагийн дипломатчид дипломат албаны түүхэн уламжлал, ахмад үеийнхээ баялаг туршлагыг өвлөн авч өнөөгийн эрхэм зорилтуудыг нэр төртэй хэрэгжүүлнэ гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлье.

Эх орныхоо гадаад харилцааг хөгжүүлэх нэр төртэй, өндөр хариуцлагатай үйл хэрэгт оюун ухаан, авъяас чадвар, хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж ирсэн манай ахмад үеийн дипломатчид, дипломат ажилтан, албан хаагчид Та бүхэнд болон танай гэр бүлийнхэнд Монгол улсад дипломат алба үүсч хөгжсөний 90 жилийн ойн баярын энэ өдөр гүн хүндэтгэлээ дахин илэрхийлж ирж буй шинэ онд ажил хөдөлмөрийн өндөр амжилт, эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.

Анхаарал тавьсанд баярлалаа.